

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/275/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ДЭГДЭЭХИЙ ЦЭЦЭРЛЭГИЙН  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishiqjargalts@audit.gov.mn](mailto:khishiqjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

**ГАРЧИГ**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/115  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН  
ДЭГДЭЭХИЙ ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.АРИУНСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд 44,851.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020269

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66,851,079.84</b>	<b>159,313,841.82</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>18,935,559.99</b>	<b>85,112,482.98</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>18,935,559.99</b>	<b>85,112,482.98</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>18,935,559.99</b>	<b>85,112,482.98</b>
<b>31</b>	Төрийн сангийн харилцах	18,935,559.99	85,112,482.98
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>47,915,519.85</b>	<b>74,201,358.84</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>47,915,519.85</b>	<b>74,201,358.84</b>
35420	Аж ахуйн материал	845,300	1,706,200
35460	Хүнсний материал	895,700	880,870
35470	Бусад хангамжийн материал	46,174,519.85	71,614,288.84
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>394,265,695.98</b>	<b>377,042,080.05</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>394,265,695.98</b>	<b>377,042,080.05</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>319,890,695.98</b>	<b>302,667,080.05</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	322,130,271.00	324,360,271.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,502,472.88)	(60,139,078.56)
39205	Машин тоног төхөөрөмж	37,619,254.00	39,238,554.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,950,493.13)	(21,096,886.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,353,434.00	47,757,434.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,759,297.01)	(27,453,213.71)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>74,375,000.00</b>	<b>74,375,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	74,375,000.00	74,375,000.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>461,116,775.82</b>	<b>536,355,921.87</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>461,116,775.82</b>	<b>536,355,921.87</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	461,116,775.82	536,355,921.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>530,815,124.00</b>	<b>530,815,124.00</b>
51101	Өмч:-төрийн	530,815,124.00	530,815,124.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(212,083,896.09)</b>	<b>(136,844,750.04)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(212,083,896.09)	(212,083,896.09)
51220	Тайлант үеийн үр дүн		75,239,146.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,385,547.91	142,385,547.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>461,116,775.82</b>	<b>536,355,921.87</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>974,975,854.09</b>	<b>665,350,917.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>477,827,754.09</b>	<b>44,851,517.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	477,827,754.09	44,851,517.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	477,827,754.09	44,851,517.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	477,827,754.09	7,547,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		37,304,517.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>497,148,100.00</b>	<b>620,499,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>391,653,000.00</b>	<b>557,237,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	391,653,000.00	557,237,700.00
<b>1310</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,514,700.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	29,514,700.00	0.00
	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>75,980,400.00</b>	<b>63,261,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	75,980,400.00	63,261,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>513,859,078.27</b>	<b>590,111,770.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>513,859,078.27</b>	<b>590,111,770.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>483,434,605.27</b>	<b>585,961,480.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>303,677,347.87</b>	<b>371,668,737.89</b>
210101	Үндсэн цалин	223,500,458.01	264,411,114.98
210102	Нэмэгдэл	68,892,155.01	100,117,719.01
210104	Урамшуулал	11,284,734.85	7,139,903.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,313,051.14</b>	<b>45,841,589.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,938,434.97	31,631,174.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,051,580.76	3,721,314.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,431,184.50	2,977,051.63
210204	Ажилгүйдлийн даатгал	527,471.59	669,571.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,364,379.32	6,842,476.89
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,226,323.00</b>	<b>56,111,409.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,380,388.00	6,330,683.93
210302	Түлш, халаалт	38,172,640.00	44,856,465.67
210303	Цэвэр, бохир ус	4,673,295.00	4,924,260.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,896,294.55</b>	<b>9,900,598.01</b>
210401	Бичиг хэрэг	4,170,550.00	6,479,700.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	80,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,725,744.55	3,340,898.01
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>46,986,330.00</b>	<b>58,256,080.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	429,000.00	0.00
210502	Хоол, хүнс	41,635,405.00	54,439,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,921,925.00	3,817,000.00

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,734,800.00</b>	<b>2,999,820.00</b>
210604	Урсгал засвар	3,734,800.00	2,999,820.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>961,900.00</b>	<b>1,092,100.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	961,900.00	1,092,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,638,558.71</b>	<b>40,091,145.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,592,855.00	10,212,230.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,087,250.00	1,981,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,958,453.71	27,897,415.93
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,424,473.00</b>	<b>4,150,290.40</b>
	Бусад урсгал шилжүүлэг	28,816,200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,863,100.00	0.00
213208	Хөдөө Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,100.00	0.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,608,273.00	4,150,290.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,608,273.00	4,150,290.40
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>461,116,775.82</b>	<b>75,239,146.05</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>461,116,775.82</b>	<b>75,239,146.05</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>497,148,100.00</b>	<b>620,499,400.00</b>
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	497,148,100.00	620,499,400.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>391,653,000.00</b>	<b>557,237,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>391,653,000.00</b>	<b>557,237,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	391,653,000.00	557,237,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,514,700.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	29,514,700.00	0.00
1330	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>75,980,400.00</b>	<b>63,261,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	75,980,400.00	63,261,700.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>478,124,540.01</b>	<b>551,195,677.01</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>478,124,540.01</b>	<b>551,195,677.01</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>447,700,067.01</b>	<b>547,045,386.61</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>303,720,212.17</b>	<b>371,654,697.23</b>
210101	Үндсэн цалин	222,393,776.24	257,017,106.01
210102	Нэмэгдэл	70,491,800.81	106,148,358.42
210104	Урамшуулал	10,834,635.12	8,489,232.80
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,270,186.84</b>	<b>45,855,629.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,790,366.55	31,699,924.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,034,290.31	3,721,314.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,427,272.20	2,977,051.63
210204	Ажилгүйдлийн даатгал	532,311.23	669,571.61
210205	Эрүүл мэндийн даатгал	5,485,946.55	6,787,767.55
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,226,323.00</b>	<b>56,111,409.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,380,388.00	6,330,683.93
210302	Түлш, халаалт	37,920,975.00	44,856,465.67
210303	Цэвэр, бохир ус	4,924,960.00	4,924,260.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>103,500</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	103,500	0.00
2105	<b>Норматив зардал</b>	<b>42,105,965.00</b>	<b>54,424,250.00</b>
210502	Хоол, хүнс	42,105,965.00	54,424,250.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,899,980.00</b>	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	2,899,980.00	3,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>961,900.00</b>	<b>1,135,000.00</b>
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	961,900.00	1,135,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,412,000.00</b>	<b>14,864,400.00</b>

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,662,000.00	11,133,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,750,000.00	3,731,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,424,473.00</b>	<b>4,150,290.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,816,200.00</b>	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,863,100.00	0.00
213208	Хөдөө Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,100.00	0.00
	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,608,273.00</b>	<b>4,150,290.40</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,608,273.00	4,150,290.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19,023,559.99</b>	<b>69,303,722.99</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>88,000.00</b>	<b>3,126,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>88,000.00</b>	<b>3,126,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>88,000.00</b>	<b>3,126,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,000.00	3,126,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(88,000.00)</b>	<b>(3,126,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>18,935,559.99</b>	<b>66,176,922.99</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>18,935,559.99</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>18,935,559.99</b>	<b>85,112,482.98</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>530,815,124.00</b>	<b>145,158,027.91</b>	<b>(223,375,717.82)</b>	<b>452,597,434.09</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,772,480.00	2,772,480.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>530,815,124.00</b>	<b>145,158,027.91</b>	<b>(220,603,237.82)</b>	<b>455,369,914.09</b>
Тайлант үеийн үр дүн			461,116,775.82	461,116,775.82
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>530,815,124.00</b>	<b>142,385,547.91</b>	<b>(212,083,896.09)</b>	<b>461,116,775.82</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн</b>	<b>530,815,124.00</b>	<b>142,385,547.91</b>	<b>(212,083,896.09)</b>	<b>461,116,775.82</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			75,239,146.05	75,239,146.05
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>530,815,124.00</b>	<b>142,385,547.91</b>	<b>(136,844,750.04)</b>	<b>536,355,921.87</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		18,935,559.99	(18,935,559.99)	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>639,435,000.00</b>	<b>554,322,477.01</b>	<b>85,112,522.99</b>	<b>86.7%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>639,435,000.00</b>	<b>554,322,477.01</b>	<b>85,112,522.99</b>	<b>86.7%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>639,435,000.00</b>	<b>550,172,186.61</b>	<b>89,262,813.39</b>	<b>86.0%</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,056,400.00	371,654,697.23	54,401,702.77	87.2%
Үндсэн цалин	282,378,100.00	257,017,106.01	25,360,993.99	91.0%
Нэмэгдэл	135,345,700.00	106,148,358.42	29,197,341.58	78.4%
Урамшуулал	8,332,600.00	8,489,232.80	(156,632.80)	101.9%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>53,257,300.00</b>	<b>45,855,629.78</b>	<b>7,401,670.22</b>	<b>86.1%</b>
Тэтгэврийн даатгал	36,214,400.00	31,699,924.31	4,514,475.69	87.5%
Тэтгэмжийн даатгал	4,261,000.00	3,721,314.68	539,685.32	87.3%
ҮОМШӨ-ний даатгал	3,408,700.00	2,977,051.63	431,648.37	87.3%
Ажилгүйдлийн даатгал	852,300.00	669,571.61	182,728.39	78.6%
Эрүүл мэндийн даатгал	8,520,900.00	6,787,767.55	1,733,132.45	79.7%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,261,700.00</b>	<b>56,111,409.60</b>	<b>4,150,290.40</b>	<b>93.1%</b>
Гэрэл, цахилгаан	6,539,900.00	6,330,683.93	209,216.07	96.8%
Түлш, халаалт	45,628,700.00	44,856,465.67	772,234.33	98.3%
Цэвэр, бохир ус	8,093,100.00	4,924,260.00	3,168,840.00	60.8%
<b>Норматив зардал</b>	<b>77,543,500.00</b>	<b>54,424,250.00</b>	<b>23,119,250.00</b>	<b>70.2%</b>
Хоол, хүнс	77,543,500.00	54,424,250.00	23,119,250.00	70.2%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>		<b>100.0%</b>
Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00		100.0%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>1,234,700.00</b>	<b>1,135,000.00</b>	<b>108,700.00</b>	<b>91.3%</b>
Мэдээлэл технологийн зардал	1,234,700.00	1,135,000.00	108,700.00	91.3%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,072,400.00</b>	<b>17,991,200.00</b>	<b>81,200.00</b>	<b>99.6%</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	14,341,200.00	14,260,000.00	81,200.00	99.4%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,731,200.00	3,731,200.00		100.0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>4,150,290.40</b>	<b>(4,150,290.40)</b>	
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>4,150,290.40</b>	<b>(4,150,290.40)</b>	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		4,150,290.40	(4,150,290.40)	

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮҮСВЭР</b>	<b>ЭХ</b>	<b>639,435,000.00</b>	<b>620,499,400.00</b>	<b>18,935,600.00</b>	<b>97.0%</b>
<b>УЛСЫН САНХҮҮЖИХ</b>	<b>ТӨСВӨӨС</b>	<b>557,237,700.00</b>	<b>557,237,700.00</b>		100.0%
Улсын төсвөөс санхүүжих		557,237,700.00	557,237,700.00		100.0%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>63,261,700.00</b>	<b>63,261,700.00</b>		<b>100.0%</b>
Орон нутгийн төсвөөс		63,261,700.00	63,261,700.00		100.0%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>18,935,600.00</b>		<b>18,935,600.00</b>	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих		18,935,600.00		18,935,600.00	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл</b>	<b>эхний</b>		<b>18,935,559.99</b>	<b>(18,935,559.99)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл</b>	<b>эцсийн</b>		<b>85,112,482.98</b>	<b>(85,112,482.98)</b>	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>		<b>22</b>	<b>22</b>		<b>100.0%</b>
Удирдах ажилтан		1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан		12	12		100.0%
Үйлчлэх ажилтан		9	9		100.0%

**2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>63,261,700.00</b>	<b>63,261,700.00</b>		<b>100.0%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>63,261,700.00</b>	<b>63,261,700.00</b>		<b>100.0%</b>
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>63,261,700.00</b>	<b>59,111,409.60</b>	<b>4,150,290.40</b>	<b>93.4%</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,261,700.00</b>	<b>56,111,409.60</b>	<b>4,150,290.40</b>	<b>93.4%</b>
Гэрэл, цахилгаан	6,539,900.00	6,330,683.93	209,216.07	96.8%
Түлш, халаалт	45,628,700.00	44,856,465.67	772,234.33	98.3%
Цэвэр, бохир ус	8,093,100.00	4,924,260.00	3,168,840.00	60.8%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>4,150,290.40</b>	<b>(4,150,290.40)</b>	
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>4,150,290.40</b>	<b>(4,150,290.40)</b>	
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		<b>4,150,290.40</b>	<b>(4,150,290.40)</b>	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>63,261,700.00</b>	<b>63,261,700.00</b>		<b>100.0%</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>63,261,700.00</b>	<b>63,261,700.00</b>		<b>100.0%</b>
Орон нутгийн төсвөөс	63,261,700.00	63,261,700.00		100.0%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>22</b>	<b>22</b>		<b>100.0%</b>
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	12	12		100.0%
Үйлчлэх ажилтан	9	9		100.0%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхэд бүр тоглоомын орчинд өөртөө итгэлтэй, чөлөөтэй сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх, хүсэл сонирхолдоо хөтлөгдсөн, идэвхтэй суралцагч байхад нь үлгэрлэн дагуулж, хамтдаа хөгжих замаар хүүхэд бүрийг “Монгол хүн болгон төлөвшүүлнэ” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 14 зорилт, хэрэгжүүлэх 58 арга хэмжээтэй баталснаас нийт 85,2%-тай дүгнэгдсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (батлагдсан:2022.11.04, хэрэгжиж эхлэх:2023.03.01)
- Монгол Улсын үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын ажил хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,239.5 мянган төгрөгөөр буюу 16,3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,935.6	85,112.5	66,176.5
Бараа материал	47,915.5	74,201.5	26,285.0
Үндсэн хөрөнгө	394,265.7	377,042.1	(17,223.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>461,116.8</b>	<b>536,356.0</b>	<b>75,239.2</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	461,116.8	536,356.0	75,239.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>461,116.8</b>	<b>536,356.0</b>	<b>75,239.2</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данснүүдэд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 66,176.9 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 26,285.8 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдээс хүлээн авсан хүүхдийн ариун цэвэр, бичиг хэргийн материалыг бүртгэж эхэлсэн, мөн 37,304.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,223.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Тайлант онд хандиваар 7,547.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 480,934.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 54,805.6 мянган төгрөг,

нийт 535,739.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 535,739.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 103,695.2 мянган төгрөгөөр өсгөн, 639,435.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 250,471.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 480,934.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 54,805.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 576,173.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 63,261.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож 4,150.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 554,322.5 мянган төгрөг буюу 86,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 89,262.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,865.6	1,865.6	0	100.0%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	77,543.5	54,424.2	23,119.3	70.0%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,893.8	3,886.3	7,5	99.0%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,865.6	1,796.0	69,6	96.0%
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	384,774.7	327,455.9	57,318.8	85.0%
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	106,230.1	101,632.7	4,597.4	96.0%
1.7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	63,261.7	59,111.4	4,150.3	93.0%
	<b>Дүн</b>	<b>639,435.0</b>	<b>550,172.1</b>	<b>89,262.7</b>	<b>87.0%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 170,708.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс 76,281.9 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 105,714.9 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 64,994.0 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 147,589.6 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 23,119.3 мянган төгрөгийн хоол, хүнсийг зарцуулаагүй болно.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 513,859.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,707.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,780.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 54,401.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 81.2 мянган төгрөг, норматив зардал 23,119.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажилласан байна.

### **Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих**

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэг бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн 16 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	53,023.7	2	53,023.7	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>53,023.7</b>	<b>2</b>	<b>53,023.7</b>	<b>100%</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 852,245.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 461,116.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж нэгтгээгүй, илтгэх хуудсыг хянаж хүлээн аваагүй 376,868.0 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа үйлчилгээний зардлын эцсийн үлдэгдэл 14,260.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн

Аудитаар 1,216.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 1.Цахим төлбөрийн баримтын бүрдэл хангахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 1,216.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлагналтай холбоотой алдаа	1	461,116.8			1	461,116.8	1	461,116.8				
Хөрөнгийн тооллогын нэгтгээгүй дүн	1	376,868.5			1	376,868.5	1	376,868.5				
Тайлагналтай холбоотой алдаа	1	14,260.0			1	14,260.0	1	14,260.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>852,245.3</b>			<b>3</b>	<b>852,245.3</b>	<b>3</b>	<b>852,245.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй	1	1,216.0					1	1,216.0					